



---

# АЛБАН ТУШААЛТНЫ ТООН ГАРЫН ҮСГИЙН ГЭРЧИЛГЭЭГ ШИНЭЭР АВАХ ЗААВАР

---

Хэрэглэгчид зориулсан гарын авлага

Боловсруулсан:

“МонПасс СА” ХХК ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ БАЙГУУЛЛАГА  
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, БЗД, 1 хороо,  
Токиогийн гудамж, НИСОРА цамхаг 702 тоот  
Утас: +976 76118632 | Факс: +976 76108632  
И-Мэйл: [info@monpass.mn](mailto:info@monpass.mn) | Веб сайт: [www.monpass.mn](http://www.monpass.mn)

Хувилбар	Огноо
1.1	2016 он

## Агуулга

### БАРИМТЫН АГУУЛГА

1.	АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА БҮРТГҮҮЛЭХ .....	4
2.	И-МЭЙЛ ХАЯГААР ИРСЭН БАТАЛГААЖУУЛАХ ЛИНК ДЭЭР ДАРЖ БАЙГУУЛЛАГЫН БҮРТГЭЛЭЭ БАТАЛГААЖУУЛАХ.....	6
3.	АЛБАН ТУШААЛТНЫ ТООН ГАРЫН ҮСГИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХҮСЭЛТИЙГ ҮҮСГЭХ.....	7
4.	ЭЗЭМШИГЧ МЭЙЛЭЭ ШАЛГАЖ, ЗАХИАЛГЫН МЭДЭЭЛЛИЙГ БАТАЛГААЖУУЛАХ.....	10
5.	ГЭРЭЭ, АЛБАН БИЧИГ ТАТАН АВЧ, ХЭВЛЭХ .....	11
6.	НЭХЭМЖЛЭХ ҮҮСГЭХ, ТӨЛБӨР ТӨЛӨХ .....	11
7.	“МОНПАСС СА” ГОБ-ЫН ГЭРЭЭТ БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГААС Е-ТОКЕН ТӨХӨӨРӨМЖИЙГ ХҮЛЭЭН АВАХ.....	14
8.	ТООН ГАРЫН ҮСГИЙН ГЭРЧИЛГЭЭГ Е-ТОКЕН ТӨХӨӨРӨМЖИД ТАТАЖ СУУЛГАХ.....	14

## БАРИМТЫН АГУУЛГА

Энэхүү баримтад аж ахуйн нэгж, байгууллагын албан тушаалтан тоон гарын үсгийн гэрчилгээ авахын тулд “МонПасс СА” Гэрчилгээ олгох байгууллага (ГОб)-д хэрхэн хүсэлт гаргаж, гэрчилгээг хүлээн авах зааврыг дэлгэрэнгүй тусгав.


Аж ахуйн нэгж байгууллага (ААНБ) нь өөрийн нэг ажилтнаар төлөөлүүлэн [www.monpass.mn](http://www.monpass.mn) веб сайтад байгууллагаа бүртгүүлэх, тус сайтад үүсгэх байгууллагын талбарыг удирдах (мэдээллийг засах, устгах, нэмэх), байгууллагын албан хаагчдыг төлөөлөн Тоон гарын үсгийн гэрчилгээний хүсэлтийг гаргах, гэрчилгээг хүчингүй болгох хүсэлт болон шинэчлэн авах хүсэлт гаргах зэрэг үйлдлийг хийж болно. Иймээс уг ажилтан нь маш хариуцлагатай, компьютер, интернэт орчинд ажиллах чадвартай хүн байх нь зүйтэй.

Албан тушаалтны тоон гарын үсгийн гэрчилгээг авахын тулд дараах дарааллын дагуу хүсэлтээ гаргаж, гэрчилгээг хүлээн авна:

1. Өөрийн аж ахуйн нэгж, байгууллагыг “МонПасс СА” ГОб-ын [www.monpass.mn](http://www.monpass.mn) сайтад онлайнаар бүртгүүлнэ.
2. Бүртгүүлсэн и-мэйл хаягаа шалгаж, баталгаажуулах линк даран байгууллагын бүртгэлээ баталгаажуулна.
3. И-мэйлээр хүлээн авсан нэр нууц үг ашиглан [www.monpass.mn](http://www.monpass.mn) –д нэвтэрч, албан тушаалтны тоон гарын үсгийн гэрчилгээний захиалга үүсгэнэ.
4. Захиалга дахь эзэмшигчийн и-мэйл руу баталгаажуулах мэйл илгээгдэх учир эзэмшигч мэйлээ шалгаж, баталгаажуулах линкийг дарна.
5. Гэрээ, албан бичиг, шаардлагатай тохиолдолд итгэмжлэлийн маягт татан авч хэвлэнэ. Удирдах албан тушаалтан гарын үсэг зурж, тамга дарна.
6. Нэхэмжлэх үүсгэж, төлбөрөө төлнө.
7. “МонПасс СА” ГОб-ын Бүртгэлийн нэгж дээр бүрдүүлсэн бичиг баримтын хамт өөрийн биеэр очин, Тоон гарын үсэг бичигдсэн Е-Токен төхөөрөмжийг хүлээн авна.
8. ГОб-аас үүсгэсэн Тоон гарын үсгийн гэрчилгээг Е-Токен төхөөрөмжид татаж, суулгана.

## 1. АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА БҮРТГҮҮЛЭХ

1.1 [www.monpass.mn](http://www.monpass.mn) веб сайтад хандан, “ШИНЭЭР ТООН ГАРЫН ҮСГИЙН ГЭРЧИЛГЭЭ АВАХ БОЛОН ЗАХИАЛАХ” цэсийг дарна.



Зураг 1. МонПасс СА ГОБ-ын веб сайт

## 1.2 БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ БҮРТГҮҮЛЭХ формыг бөглөөд “Бүртгүүлэх” товч дарна.

Байгууллагын мэдээлэл бүртгүүлэх

мэдээллээ ашиглан [www.monpass.mn](http://www.monpass.mn) сайтын баруун дээд өнцөгт байрлах “Нэвтрэх” хэсэгт дарж нэр, нууц үгээ оруулж нэвтрэнэ.

**ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ**

\* Улсын бүртгэлийн дугаар: 0123456789 \* Регистрийн дугаар: 1234567  
\* НД төлөгчийн дугаар: 000023456 \* Байгууллагын нэр: АЗ ХХК

**УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЭЛ**

\* Эцэг/Эх-ийн нэр: Баатар Гадаад иргэн эсэх:   
\* Нэр: Оюун \* Регистр дугаар: НН70010101  
\* Албан тушаал: Захирал


**ХАЯГИЙН МЭДЭЭЛЭЛ**

\* Аймаг / Нийслэл: Улаанбаатар 01 байр 01 тоот  
\* Сум / Дүүрэг: Баянгол дүүрэг  
Баг / Хороо: 1-р хороо

**БҮРТГЭЛ ОРУУЛСАН АЖИЛТАН**

**ТАЙЛБАР**  
И-мэйл хаягаа үнэн, зөв бичнэ үү. Бүртгэлийг баталгаажуулсаны дараа нэвтрэх мэдээллийг и-мэйл хаягаар илгээх болно

\* Эцэг/Эх-ийн нэр: Дорж \* Албан тушаал: Хүний нөөцийн ажилтан  
\* Өөрийн нэр: Цэцэг Гадаад иргэн эсэх:   
\* И-мэйл: az@az.mn \* Регистр дугаар: НН80101010  
\* Утас: 99887766  
\* Зурган кодыг оруулна уу:

Би машин биш 

Бүртгүүлэх Хаах

**Анхаар:**

! Байгууллагын мэдээллийг бөглөхдөө **Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний** мэдээллийг үндэслэн үнэн зөв, алдаагүй бичнэ үү.


! “\*” тэмдэг бүхий талбаруудыг заавал бөглөнө.

! “Бүртгүүлэх” товч дарсны дараа таны бүртгүүлсэн и-мэйл хаягаар хэрэглэгчийн талбарт нэвтрэх мэдээлэл (Нэр, Нууц үг) ирэх тул и-мэйлээ шалгаж, баталгаажуулах линк дарна.

Зураг 2. Байгууллагын мэдээлэл бүртгүүлэх форм

## 2. И-МЭЙЛ ХАЯГААР ИРСЭН БАТАЛГААЖУУЛАХ ЛИНК ДЭЭР ДАРЖ БАЙГУУЛЛАГЫН БҮРТГЭЛЭЭ БАТАЛГААЖУУЛАХ

2.1 Байгууллага бүртгүүлэх формд бүртгүүлсэн и-мэйлээ шалгаж, баталгаажуулах линк дээр дарахад: “Амжилттай баталгаажууллаа. Танд баярлалаа” гэсэн бичиг харуулна.




Зураг 3. И-мэйл хаягаа шалгаж, Байгууллагын бүртгэл баталгаажуулах

### Анхаар:

**!** Хэрэв таны и-мэйл хаягаар ямар нэг и-мэйл ирээгүй бол та и-мэйл хаягаа буруу бүртгүүлсэн байж болзошгүй тул ГОБ-ын холбогдох утсаар хандаж и-мэйл хаягаа засуулах шаардлагатай.

### 3. АЛБАН ТУШААЛТНЫ ТООН ГАРЫН ҮСГИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХҮСЭЛТИЙГ ҮҮСГЭХ

3.1 [www.monpass.mn](http://www.monpass.mn) сайтад хандаж, баруун дээд буланд байрлах “НЭВТРЭХ” линк дээр дарж, и-мэйл хаягаар хүлээн авсан Нэвтрэх нэр, нууц үгийг ашиглан хэрэглэгчийн талбарт нэвтрэнэ.



Зураг 4. Хэрэглэгчийн талбарт нэвтрэх цонх

3.2 Хэрэглэгчийн талбарт амжилттай нэвтэрсний дараа **Байгууллагын мэдээлэл** бүхий цонх нээгдэнэ. Хэрэв байгууллагын мэдээлэл нь Нийгмийн даатгалын систем дэх мэдээллээс зөрсөн тохиолдолд энэ тухай Анхааруулгыг нэвтрэх үед харуулах тул “Засах” товч дээр дарж, алдаатай мэдээллийг засаж хадгална.

**УУЧЛААРАЙ**  
Мэдээлэл зөрсөн төлөвтэй байна. Мэдээллээ няглан дахин оруулна уу.

**ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ**

- КОМПАНИ МЭДЭЭЛЭЛ
- МИНИЙ ЗАХИАЛГУУД
- ОЛГОГДСОН ТООН ГАРЫН ҮСГҮҮД
- НЭХЭМЖЛЭХҮҮД
- ХҮЧИНГҮЙ ГЭРЧИЛГЭЭ

**Байгууллагын мэдээлэл**

**ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ**

* Улсын бүртгэлийн дугаар:	1233456654	* Регистрийн дугаар:	1234567
* НД төлөгчийн дугаар:	000234567	* Байгууллагын нэр:	АЗ ХХК

**УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЭЛ**

* Эцэг/Эх-ийн нэр:	Баатар	* Регистрийн дугаар:	НЭ70101010
* Нэр:	Оюун	* Албан тушаал:	Захирал

**ХАЯГИЙН МЭДЭЭЛЭЛ**

* Аймаг / Нийслэл:	Улаанбаатар	01 байр 01
* Сум / Дүүрэг:	Баянгол дүүрэг	
Баг / Хороо:	1-р хороо	

**БҮРТГЭЛ ОРУУЛСАН АЖИЛТАН**


* Албан тушаал:	Хүний нөөцийн ажилтан	* Эцэг/Эх-ийн нэр:	Дорж
* Өөрийн нэр:	Цэцэг	* Регистрийн дугаар:	НН98080011
* И-мэйл хаяг:	info@monpass.mn	* Утас:	88988888

**Засах**

Зураг 5. Байгууллагын мэдээлэл



3.3 “МИНИЙ ЗАХИАЛГУУД” цэс рүү орж, “Шинэ захиалга үүсгэх” товчийг дарна. “ШИНЭ ЗАХИАЛГА ҮҮСГЭХ” формд Тоон гарын үсгийн гэрчилгээ авах албан тушаалтны мэдээллийг бөглөж, “ХАДГАЛАХ” товч дарна. Дахин шинэ хүсэлт нэмж үүсгэх бол “Шинэ захиалга үүсгэх” товчийг дахин дарж, шинээр форм бөглөж, хадгална.



**Шинэ захиалга үүсгэх**

ЭЗЭМШИГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

\* Ургийн овог: Боржигон Гадаад иргэн эсэх:

\* Эцэг/Эхийн нэр: Баатар \* Регистрийн дугаар: НЭ80000000

\* Өөрийн нэр: Ариун \* Хүйс:  Эр  Эм

БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

\* Компани нэр: АЗ ХХК \* Салбар / Хэлтэс: Захиргаа

\* Албан тушаал: Нягтлан

ТООН ГАРЫН ҮСГИЙН МЭДЭЭЛЭЛ

1	Ажилтаны тоон гарын үсгийн гэрчилгээ /Class-3/ 1 жил	<input checked="" type="radio"/> 1 жил <input type="radio"/> 2 жил	40,000.00
2	Тоон гарын үсгийн тээгч төхөөрөмж (eToken storage)	<input checked="" type="radio"/> Тийм <input type="radio"/> Үгүй	40,000.00
Бараа ажил үйлчилгээний үнэ:			80,000.00
НӨАТ:			8,000.00
Нийт дүн:			88,000.00

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

\* И-мэйл хаяг: ariunaa36@yahoo.com Тайлбар

Хоёр дахь и-мэйл хаяг:

Холбоо барих утас: 9900000000

Тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмших гэрээ үзэг барууны талд

Би гэрээний нөхцөлийг зөвшөөрч байна

Хадгалах Хаах

**Анхаар: Шинэ захиалга үүсгэх формыг бөглөхдөө**

**!** Гэрчилгээний хугацааг 1 эсвэл 2 жилээр сонгож болно. Хэрэв ажилтан нь анх удаа “МонПасс СА” ГОБ-ын тоон гарын үеэг үухиалж байгаа бол Тоон гарын үсгийн тээгч төхөөрөмж мөрөнд “Тийм” сонголтыг сонгож, Э-төхөөрөмж заавал авна.

**!** Тоон гарын үсгийн гэрчилгээний хүсэлтийн формыг бөглөсний дараа **ТООН ГАРЫН ҮСГИЙН ГЭРЧИЛГЭЭ ЭЗЭМШИХ ГЭРЭЭГ** уншиж, “Би гэрээний нөхцөлийг зөвшөөрч байна” тэмдгийг сонгосноор хадгалах боломжтой болно.

**!** И-мэйл хаяг мөрөнд зөвхөн тухайн формд бүртгүүлж буй тоон гарын үсэг эзэмших хүний албан эсвэл хувийн и-мэйл хаягийг бичнэ.

Зураг 6. Тоон гарын үсгийн гэрчилгээний хүсэлтийн форм

## 4. ЭЗЭМШИГЧ МЭЙЛЭЭ ШАЛГАЖ, ЗАХИАЛГЫН МЭДЭЭЛЛИЙГ БАТАЛГААЖУУЛАХ

4.1 Захиалга үүсгэж хадгалсны дараа захиалгын төлөв нь “Баталгаажуулах” болох ба захиалга дээрх мэйл хаягаар баталгаажуулах мэйл илгээгдэнэ:

Хувийн мэдээлэл

- КОМПАНИ МЭДЭЭЛЭЛ
- МИНИЙ ЗАХИАЛГУУД**
- ОЛГОГДСОН ТООН ГАРЫН ҮСГҮҮД
- НЭХЭМЖЛЭХҮҮД
- ХҮЧИНГҮЙ ГЭРЧИЛГЭЭ

Тоон гарын үсгийн захиалга

Шинэ захиалга үүсгэх | Итгэмжлэлийн маяг | Гэрээ | Албан бичиг

<input type="checkbox"/>	Регистр	Овог, нэр	Хэлтэс/Албан тушаал	Нэхэмжлэх	Төлбөр	Төлөв
<input type="checkbox"/>	НЭ70101010	Б.Ариун	Захиргаа / Захирал		88,000	<b>Баталгаажуулах</b>
Нийт дүн:					88,000	

Зураг 7. Захиалга

4.2 Эзэмшигч /жишээ ёсоор Б.Ариун/ өөрийн и-мэйл хаяргуу нэвтэрч, мэйл дэх захиалгын мэдээллийг шалгаад, бүгд зөв бол “Баталгаажуулах линк” дээр дарж баталгаажуулна. Амжилттай баталгаажуулсны дараа захиалгын төлөв “Шинэ” болно:

Тоон гарын үсгийн хүсэлт баталгаажуулах.

**МОНПАСС СА** <support@monpass.mn> Today at 1:18  
To: ariunaa36@yahoo.com

Эрхэм хүндэт Энэ өдрийн мэндийг хүргэе!

Тоон гарын үсгийн гэрчилгээ авах хүсэлт амжилттай үүссэн байна. Та доорх мэдээллийг нягталж энд дарж баталгаажуулна уу:

Овог: Баатар | Нэр: Ариун | Албан тушаал: Захирал | Холбоо барих утас: 999999999 | Тоон гарын үсгийн гэрчилгээ төрөл, хугацаа: Ажилтаны тоон гарын үсгийн гэрчилгээ /Class-3/ 1 жил | Тээгч төхөөрмж авах эсэх:

Баталгаажуулах

Зааврын дагуу баталгаажуулах явцад асууж тодруулах зүйл гарвал бидэнтэй холбогдоно уу.

Танд амжилт хүсье.  
Хүндэтгэсэн,

**MONPASS CA**  
Утас: +976-76103286 | +976-76113286  
И-Мэйл: info@monpass.mn  
Вэб: www.monpass.mn  
Skype: monpassca.mn  
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1-р хороо Токиогийн гудамж 14А Нисора цамхаг, 702 тоот

Reply, Reply All or Forward | More

НҮҮР ХУУДАС | ВЕБ САН | БҮТЭЭГДЭХҮҮН |

АМЖИЛТТАЙ БАТАЛГААЖУУЛЛАА, ТАНД БАЯРЛАЛАА.

Тоон гарын үсгийн захиалга

Шинэ захиалга үүсгэх | Итгэмжлэлийн маяг | Гэрээ | Албан бичиг

<input type="checkbox"/>	Регистр	Овог, нэр	Хэлтэс/Албан тушаал	Нэхэмжлэх	Төлбөр	Төлөв
<input type="checkbox"/>	НЭ70101010	Б.Ариун	Захиргаа / Захирал		88,000	<b>Шинэ</b>
Нийт дүн:					88,000	

Зураг 8. И-мэйл хаягаас захиалга баталгаажуулах

## 5. ГЭРЭЭ, АЛБАН БИЧИГ ТАТАН АВЧ, ХЭВЛЭХ

5.1 Тоон гарын үсгийн гэрчилгээ авах албан хаагчдын хүсэлтийг үүсгэж дуусаад, Тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмших гэрээ болон Албан бичгийг /шаардлагатай бол Итгэмжлэлийн маягт/ татан авч, Тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмших гэрээг 2%, Албан бичгийг 1% хэвлэнэ. Татаж авахын тулд Миний захиалгууд цэсийн “ГЭРЭЭ”, “АЛБАН БИЧИГ” товчнууд дээр тус тус дарна.

✓	Регистр	Овог, нэр	Хэлтэс/Албан тушаал	Нэхэмжлэх	Төлбөр	Төлөв
✓	ШҮ78787787	Д.Эрдэнэ	Санхүү / Нягтлан		121,000	Баталгаажуулах
✓	НЭ70101010	Б.Ариун	Захиргаа / Захирал		88,000	Шинэ
Нийт дүн:					209,000	

Зураг 9. Гэрээ, албан бичиг татаж авах

## 6. НЭХЭМЖЛЭХ ҮҮСГЭХ, ТӨЛБӨР ТӨЛӨХ

6.1 “НЭХЭМЖЛЭХҮҮД” цэсийн “НЭХЭМЖЛЭХ ҮҮСГЭХ” товч дээр дарж, захиалгын нийт үнийн дүнгээр 1 нэхэмжлэх үүсгэн, “ХАДГАЛАХ” дарж, хадгална.

“Татах” товч дээр дарж, нэхэмжлэхийг татаж авна. Нэхэмжлэхийн төлбөрийг онлайн үйлчилгээ ашиглан картаар төлөх эсвэл банкинд очиж бэлнээр төлж болно.

Зураг 10. Нэхэмжлэхүүд цэс

**НЭХЭМЖЛЭХ**

МОНПАСС СА

Төмөр тоо: 2205110546

Утас/Факс: 976-76103286  
info@monpass.mn  
http://www.monpass.mn

Монгол улс, Улаанбаатар хот,  
Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Нисора  
цэнхэг - 702, 703 тоот

**ТӨЛӨГЧ**  
АЗ ХХК  
1234567  
88988888  
Монгол улс, Улаанбаатар, Баянгол дүүрэг, 1-р  
хороо, 01 байр 01

**НЭХЭМЖЛЭХ**

Мөнгөн дүн төгрөгөөр

№	Гүйлгээний утга	Тоо ширхэг	Нэглийн үнэ	Нийт үнэ
1	Ажилтаны тоон гарын үсгийн гэрчилгээ /Class-3/ 1 жил	1	40,000.00	40,000.00
2	Тоон гарын үсгийн тээгч төхөөрөмж (eToken storage)	1	40,000.00	40,000.00

Барав ажил үйлчилгээний үнэ: 80,000  
НӨАТ: 8,000  
Нийт дүн: 88,000.00

Хадгалах Хаах

Нэхэмжлэхүүд

Нэхэмжлэх үүсгэх




Нэхэмжлэх №	Огноо	Нэхэмжилсэн	Төлөв	Үйлдэл	Устгах
147314016754	2016/09/06	88,000	Шилнэ	Картаар төлөх Татах	Устгах
Нийт дүн:		88,000			

**АНХААР!**

Картаар төлбөр хийсэд ХААН банкны картаас бусад бүх банкны картаар төлбөрийг хийж болно. Хэрэв Та онлайн төлбөрийн систем ашиглан, эсвэл банкинд очиж төлбөр шилжүүлэх бол Гүйлгээний утга талбарт зөвхөн татаж авсан Нэхэмжлэхийн дугаар болох # тэмдгийн арын 12 оронтой тоог бичнэ үү. (Жишээ нь, Гүйлгээний утга: 468123456789)

Зураг 11. Нэхэмжлэх үүсгэж, ХАДГАЛАХ

- **Төлбөрийг банкинд бэлнээр** төлөхийг хүсвэл төлбөрийн нэхэмжлэхийн дагуу Голомт банкны 2205110546 тоот дансанд төлбөрийг шилжүүлж, төлбөр төлсөн баримтыг авна. Банкны баримтын гүйлгээний утга талбарт зөвхөн **Нэхэмжлэхийн дугаар** болох 12 оронтой тоог бичнэ.
- **Картаар** төлбөр төлөхийг хүсвэл **Нэхэмжлэхүүд** цэсээс төлбөр хийгдэх нэхэмжлэхийн харгалзах мөрөнд буй **“КАРТААР ТӨЛӨХ”** товчийг дарна.

**GOLOMT BANK** Committed to and Investing in Excellence   

**Гүйлгээний мэдээлэл / Order information**

Байгууллагын дугаар (Merchant ID) **MONPASS CA LLC**

Гүйлгээний дүн (Amount) **88,000.00 MNT**

Нэхэмжлэлийн дугаар (Invoice number) **147314048627**


**Төлбөрийн картын мэдээлэл / Card information**

UnionPay карт бол энд дарна уу / Using UnionPay, click here.

Картын дугаар (Card number)

Карт эзэмшигчийн нэр (Cardholder name on card)

Хүчинтэй хугацаа (Expiration date)

CVV код (Card Verification Number)   CVV код | AmEx?

Э-майл (Email)

Утасны дугаар (Phone number)

**Төлбөр хийх/Do payment**

Verified by **MasterCard** AMERICAN EXPRESS **VISA** **SecureCode** **SafeKey** Secured by Golomt bank of Mongolia 2008 About SSL Certificates

**Анхаар:                   Онлайнаар төлбөр төлөхдөө**

**!** Гүйлгээний дүн зөв эсэхийг нягтлана уу.

**!** Төлбөрийн картын мэдээллээ үнэн зөв оруулаад, **Төлбөр хийх** товчийг дарна. Хэрэв мэдээлэл зөв оруулсан тохиолдолд “Гүйлгээ амжилттай боллоо”, буруу тохиолдолд “Гүйлгээ амжилтгүй боллоо” гэсэн мэдээлэл гарах болно.

Зураг 12. Онлайн төлбөрийн систем ашиглан картаар төлбөр төлөх

## 7. “МОНПАСС СА” ГОБ-ЫН ГЭРЭЭТ БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГААС Е-ТОКЕН ТӨХӨӨРӨМЖИЙГ ХҮЛЭЭН АВАХ

**7.1** Тоон гарын үсгийн гэрчилгээний онлайн захиалгыг хийж, төлбөрийг төлсний дараа ТГҮГ эзэмших ажилтан баримт бичгүүдийн хамт, “МонПасс СА” ГОБ-ын дараах Бүртгэлийн салбар нэгжийн аль нэг дээр очно:

- “МонПасс СА” Гэрчилгээ олгох төв;
- “Дүнжингарав” худалдааны төв дэх Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв дээрх Тоон гарын үсэг олгох цэг;

### **БҮРДҮҮЛЭХ БАРИМТ:**


- Байгууллагын албан бичиг (онлайн захиалга хийх явцад татан авч, хэвлэх ба байгууллагын захирлын гарын үсэг, тамгаар баталгаажсан байх);
- Гэрээ 2% (онлайн захиалга хийх явцад татан авч, хэвлэх ба хүсэлт гаргагч гарын үсэг зурж, байгууллагын захирлын гарын үсэг, тамгаар баталгаажсан байх);
- Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажсан хуулбар;
- Иргэний цахим үнэмлэх болон хуулбар;
- Бусдаар төлөөлүүлэн авах тохиолдолд итгэмжлэл (Итгэмжлэлийн маягтыг заавал нотариатаар баталгаажуулсан байх );

**7.2** Э-Токен төхөөрөмжийг хүлээн авна. Эзэмшигч Э-Токенд хандах PIN кодыг өөрийн и-мэйл хаягаар хүлээн авна.

## 8. ТООН ГАРЫН ҮСГИЙН ГЭРЧИЛГЭЭГ Е-ТОКЕН ТӨХӨӨРӨМЖИД ТАТАЖ СУУЛГАХ


“МонПасс СА” ГОБ нь захиалгыг шалгаж, тоон гарын үсгийн гэрчилгээг үүсгэсэн даруй, эзэмшигчийн и-мэйл хаягаар Тоон гарын үсэг амжилттай олгогдсон тухай мэдэгдэл болон гэрчилгээг татаж суулгах заавар ирнэ. Гэрчилгээг Э-Токен төхөөрөмжид татаж суулгахдаа “Monpass Client” програм ашиглан дараах зааврын дагуу суулгана:

1. “Monpass Client” програмыг [www.monpass.mn/support](http://www.monpass.mn/support) хаягаас татан авч суулгаад, програмыг нээнэ.



Зураг 13. “Monpass Client” програмын үндсэн цонх

2. “Шинэ гарын үсэг суулгах” цэс дээр дарна. “Хүлээгдэж байгаа тоон гарын үсэг” жагсаалт дахь гэрчилгээний мэдээлэл “Баталгаажсан” төлөвтэй харагдаж байвал “Суулгах” товч дээр дарж гэрчилгээг Э-Токенд суулгана.



Зураг 14. “Шинэ тоон гарын үсэг суулгах” цонх

! “Monpass Client” програмыг татаж авах, суулгах, ашиглах зааврыг [www.monpass.mn/support](http://www.monpass.mn/support) хаягаас татаж авна уу.